



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/108

Сангийндалай

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дуусаж сунгуулах хүсэлт ирүүлсэн 61 иргэний өвөлжөө, хаваржааны доорх газрыг зориулалтын дагуу 40 жилийн хугацаатайгаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж байгаа иргэдийн нэрс, байршил, хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Дээрх иргэдийн материалыг хууль журмын дагуу бүрдүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан ажиллахыг Газрын даамал (Э.Ууганцэцэг)-т даалгасугай.

4. Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 05 дугаар, 2008 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 38 дугаар, 2008 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 46 дугаар захирамжуудыг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЛХАГВАМАНДАЛ

482302215